

МОНГОЛЫН ТАЛААРХИ ОРОСЫН ГАДААД УЛС ТӨРИЙН СТРАТЕГИ

*В.А.Родионов**

Исследование выполнено при финансовой поддержке РГНФ в рамках научно-исследовательского проекта РГНФ “Российское присутствие в Монголии: модернизация “советских” институтов на “постсоветском” пространстве”

(Тухайн судалгаа нь Оросын Төрийн Шинжлэх Ухааны Фондын дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй “Монгол дахь Оросын оролцоо: “Зөвлөлт Холбоот Улс задарсны дараахи” зөвлөлтийн институтуудын шинэчлэл” хэмээх ОТШФ-ын судалгааны төслийн хүрээнд гүйцэтгэв)

2000-аад оны эхний хагаст Орос, Монгол нь дээд хэмжээнд харилцаа холбоогоо эрс нэмэгдүүлснээр төрийн болон парламент, засгийн газрын тэргүүнүүдийн харилцан айлчлал тогтмолжиж хоёр орны хоорондын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх хамтын ажиллагаа идэвхжив. 2000 оноос жил бүр Монгол Улсад хийх Оросын удирдагчдын дээд болон өндөр хэмжээний айлчлал сэргэв. Тухайлбал 2000-2009 оны хооронд Оросын Холбооны Ерөнхийлөгч /хоёр удаа/, засгийн газрын тэргүүн /гурван удаа/, хууль тогтоох байгууллагын төлөөлөгч болон холбооны сайд нар /удаа дараа/ Монгол Улсад тус тус айлчлав. Үүнээс гадна хоёр орны Ерөнхийлөгч В.В.Путин, Н.Энхбаяр нарын гарын үсэг зурсан 2006 оны Москвагийн тунхагт “социализмын дараах үед” анх удаа талууд хоёр орны олон талт хамтын ажиллагааны үр дүнг чанарын шинэ шатанд гаргаж стратегийн түншлэлийн хэмжээнд нэмэгдүүлэх эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлсэн үг үсэг бүхий санааг тусгасан болно.¹

Үүний зэрэгцээ Орос, Монголын хоорондын худалдаа эдийн засгийн харилцааны түвшинг улс төрийн хамтын ажилгааны өндөр түвшинд нийцүүлэн хүргэх гэсэн стратегийн зорилтыг тодорхойлсон болно. Үүнтэй төстэй зорилтыг 2006 оны Москвагийн тунхагт ч мөн тэмдэглэсэн байдаг.² Үүнд юуны түрүүнд уул уурхайн салбар дахь хоёр орны хамтын ажиллагаа хийгээд Монгол дахь нүүрс, зэс, ураны том ордуудыг ашиглах тухай санаа туссан байдаг.

Гэвч энэхүү зорилтыг хэрэгжихэд Оросын тал зарим хүндрэлтэй тулгарсан юм. Тухайлбал, мөнгөний /Асгат/, нүүрсний /Таван толгой/ зэс болон алтны /Оюу Толгой/ ураны ордууд /Дорнодын/-ыг ашиглах эрхийг тэдэнд олгоно гэсэн Оросын компаниудын найдлага талаар болсон ба болсоор байна.

Бидний үзэж байгаагаар Монгол дахь Оросын эдийн засгийн ашиг сонирхлыг амжилттай урагшлуулахад саад тогтор учруулж буй хүчин зүйлүүдийн нэг бол Москвагийн зүгээс Монголын талаар явуулж буй алдаатай бодлого юм. Бодлогын алдаа нь үндсэн хоёр зүйлийн төөрөгдлөөс улбаатай хэмээн үзэж байна.

* В.А.Родионов - ОХУ-ын Буриад улсын Их Сургуулийн Түүх, археологи, этнографийн кафедрын доцент, улс төрийн шинжлэх ухааны доктор

Нэгд. Монголд “оросын” болон “барууны” /өөрөөр хэлбэл Оросын эсрэг/ талыг баримтлагч хүчнүүд бий. Оросын талыг баримтлагч хүчинд Монгол Ардын Хувьсгалт нам /МАХН/, хоёр дахь хүчинд Монголын ардчилсан нам /МАН/ тэргүүтэй сөрөг хүчний намуудын ихэнхи хамаарна. Иймээс чухамхүү МАХН-ыг бүхий л талаар дэмжих хэрэгтэй гэсэн төөрөгдөл

Хоёрт. Монгол дахь эдийн засгийн юуны түрүүнд хамгийн ирээдүйтэй уул уурхайн салбар дахь Оросын ашиг сонирхлыг нь урагшлуулах баталгаа бол Москва, Улаанбаатарын хооронд улс төрийн өндөр түвшин дэх харилцаа хийгээд удирдагчид нарын хоорондын хувийн дотно харилцаа гэсэн бас нэг төөрөгдөл.

Нэгдүгээр төөрөгдөл нь Оросын албан ёсны төлөөлөгчдийн зүгээс МАХН-ыг парламентын болон ерөнхийлөгчийн сонгуульд илтээр дэмжснээр илэрсэн. 2008 онд Төрийн Думын олон улстай харилцах хорооны гишүүн Р.Кондратов³ Монголд айлчлах үедээ ирэх ардчилсан сонгуульд МАХН-ыг дэмжихээ мэдэгдсэн болно. Түүнчлэн 2008 оны парламентын сонгуулийн өмнө төр барьж буй “Нэгдсэн Орос” болон МАХН-ын хооронд “Хамтын ажиллагааны гэрээ” байгуулах тухай тохиролцоогоо хоёр тал дахин батлав. “Нэгдсэн Орос” намын төлөөлөгч К.Косачёв “МАХН-ыг түншийн хувьд сонгож байгаа нь стратегийн сонголт юм”⁴ хэмээн мэдэгдэв. Оросын элчин сайдын яамны тэргүүн Б.А.Говорин “Аист-Монголия” телевизэд ярилцлага өгөхдөө оппозици намуудыг шүүмжлэн тэднийг 2008 оны Их хурлын сонгуулийн дараах үймээн самууныг зохион байгуулсан хэмээн буруутгав.⁵ Монголын Ардчилсан Нам үүнийг тусгаар улсын хэрэгт хөндлөнгөөс оролцох гэсэн оролдлого хэмээн дүгнэн буруушаав.

Оросын засаглалын МАХН-д хандаж буй энэхүү хандлагыг доорхи зүйлээр тайлбарлаж болох юм. Нэгдүгээрт, хоёр тал харилцан бие биендээ анхаарлаа нэмэгдүүлэх явц цаг хугацааны хувьд Монголд МАХН дангаар ноёрхож байсан яг тэр цаг үетэй давхцаж байгаа явдал юм. Чухамхүү Улсын Их Хуралд 2000-2004 он хүртэл хугацаанд 76 суудлаас 72 нь МАХН-д ноогдож байсан⁶ бөгөөд мөн Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын суудлыг МАХН-ын гишүүн тус тус эзэлж байсан болно. Оросын тал магадгүй үүнийг бие биетэйгээ ойртоход шийдвэрлэх хүчин зүйл гэж ойлгосон байж магад. Хоёрт, бүр социализмын үеэс улбаатай МАХН болон Оросын зарим улс төрийн элитүүдийн хоорондын харилцаа холбоо зохих хувь нэмрээ ч оруулсан байж болох юм. Тэр тусмаа МАХН нь Оростой хийх гэрээ хэлэлцээрийн явцад өөрийгөө “Оросын талыг баримтлагч хүч” гэсэн имиджийг байнга төрүүлж оппозици намуудыг Оросын эсрэг байр суурьтай барууны талыг баримтлагч гэсэн сэтгэгдлийг төрүүлсээр ирсэн. Гэвч энэ нь бодит амьдрал дээр тэр бүр нотлогдохгүй байгаа юм. Учир нь МАХН нь нэгэн зэрэг Хятад, Япон, Солонгос, барууны орнуудтай үүнээс ч дутахааргүй хэмжээнд идэвхтэй хамтран ажилласаар байгаа юм. Тухайлбал, Олон улс болон бүс нутгийн хэмжээнд чухал ач холбогдол бүхий АНУ-тай хамтарсан “Khan Quest” хэмээх Монголын нутаг дэвсгэр дээр болдог цэргийн хээрийн сургууль нь 2003 оноос чухамхүү МАХН-аас

сонгогдсон ерөнхийлөгч Н.Багабанди, Ерөнхий сайд Н.Энхбаяр мөн Улсын Их Хуралд МАХН олонхи болж байх тэр үед эхэлсэн билээ.

МАХН-тай харьцуулах юм бол Монголын Ардчилсан Нам, Монголын Социалист Ардчилсан Нам, “Иргэний зориг” намууд нь Оростой сайн харьцаатай байх талаар аль болохоор бага дурсдаг бөгөөд юуны өмнө барууны орнуудтай, ялангуяа АНУ-тай нягт хамтран ажиллахын төлөө байдаг. Гэхдээ эдгээр намуудын удирдлагуудын Оросын эсрэг хандлага болон барууны талын байр суурийг нь хэтрүүлэн үнэлж болохгүй юм. Гадаад улс төрийн бодлого дахь тэргүүлэх чиглэлийн талаархи гол гол намуудын байр суурь, маргаан нь ихэнх тохиолдолд цаг үеийн конъюнктур шинжтэй бөгөөд энэ нь нам хоорондын улс төрийн тэмцлийн зүй тогтлоор тайлбарлагдана. Сонгуулийн тэмцлийн явцад өрсөлдөгчийн гадаад улс төрийн үйл ажиллагаа, үзэл баримтлалыг шүүмжлэх нь улс төрийн үйл ажиллагааны салшгүй л нэг хэсэг мөн.

Гэтэл чухамдаа ярих юм бол гадаад улс төрийн бодлого дахь тэргүүлэх чиглэлийн талаархи маргаан нь Монголын гадаад бодлогын үндсийг хөнддөггүй. Гадаад бодлогын зарим нэгэн тодорхой асуудлаархи маргаан нь нэгдсэн стратегийг боловсруулах болон хэрэгжүүлэхэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэггүй. Монголын төр, нийгмийн зүтгэлтнүүдийн ихэнхи нь тэдний намын харъяалал, улс төрийн үзэл баримтлалаас нь үл хамааран Орос, Хятад, барууны орнуудыг түшиглэсэн олон талт гадаад бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатайг хүлээн зөвшөөрдөг ба чингэхдээ хүчний төвүүдийн алийг нь ч онцолдоггүй болно.

Иймээс Оросын засгийн газар зөвхөн МАХН-ыг дэмжиж байгаа нь зүйрлэвээс “өндөгнүүдийг нэг сагсанд хийнэ” гэсэн үг бөгөөд Монголын дотоод улс төрийн байдал байнга өөрчлөгдөж буй нөхцөлд чингэх нь алсын хараагүй /харалган/ явдал юм. Оросын энэхүү тактик алдаатай байсныг 2009 оны Монголын ерөнхийлөгчийн сүүлчийн сонгууль бэлэхнээ харуулав. Сонгуульд Ардчилсан намаас дэвшигч Ц.Элбэгдорж ялж 2009 оны 5-р сард Улаанбаатарт болсон В.В. Путины айлчлалын үеэр Оросын талаас албан ёсны бус ч гэлээ дэмжлэг авсан тухайн үеийн Ерөнхийлөгч Н.Энхбаярыг ардаа орхив. Оросын ерөнхий сайд зөвхөн МАХН-ын төлөөлөгчидтэй уулзаж сөрөг хүч болох МАН-ын төлөөлөгчдөд зохих анхаарлаа хандуулаагүй билээ.⁷

Гэтэл Ц.Элбэгдорж Ерөнхийлөгчийн тангараг өргөх үедээ “дэлхийн бүх оронтой найрсаг харилцааг хөгжүүлэх хийгээд ялангуяа хөрш хоёр оронтой /Орос, Хятадтай В.Р./⁸ сайн хөршийн харилцааг бэхжүүлэх бодлогыг үргэлжлүүлнэ хэмээн мэдэгдэж олон талт гадаад бодлогыг тууштай баримтлана гэдгээ нотолсон юм. Ийнхүү Ц.Элбэгдоржийг барууны талыг баримтлагч гэж хэт дэвэргэсэн байдаг. Гэтэл тэрээр үнэндээ үндэсний эрх ашгийг баримтлагч прагматик л үзэлтэн юм.

Хоёр дахь төөрөгдөл бол 2000 онуудад Орос Монголтой улс төрийн талаар ойртсон нь Оросын хөрөнгөтнүүдэд Монголын эрдэс баялгийг олборлох давуу эрхийг автоматаар олгоно гэсэнд оршино. Энэхүү төөрөгдөл ялангуяа Оюу Толгойн зэс алтны жишээн дээр тодорхой илэрсэн болно.

Бүр 2009 оны зун Оросын засгийн газрын дэмжлэгийг авсан “Российские железные дороги” ХХК- ийн удирдлага энэхүү ордын боловсруулалтын лицензийг олж авна гэдэгт ихэд найдвар тавьж их л өөдрөг байв. (Албан бус мэдээгээр) энэхүү өөдрөг сэтгэл нь 2009 оны 5-р сард В.В.Путин Монголд айлчлах үеэрээ Монголын Ерөнхий сайд С.Баяр болон Ерөнхийлөгч Н.Энхбаяртай хувийн журмаар хийсэн (аман) тохиролцооны үр дүнд бий болсон ажээ. Гэвч 2009 оны 10-р сард Монголын засгийн газар Оюу-Толгойн олборлолтын лицензийг Канад-Австралийн хамтарсан “Айвенхоу Майнз” (Ivanhoe Mines) болон Рио Тинтод (Rio Tinto) шилжүүлэв. Манай дотоодын шинжээчид энэхүү үйл явдлыг Оросод таагүй ханддаг Ц.Элбэгдорж Ерөнхийлөгчээс болсон⁹ гэж ихэнхдээ тайлбарладаг. Чингэхдээ тэд чухамхүү Монголын талаас МАХН-аас сонгогдсон ерөнхий сайд С.Баяр МАХН-ын олонхоос бүрддэг /76-аас 47/ Их Хурлын баталснаар лиценз эзэмших гэрээг үзэглэсэн гэдгийг тэр бүр харгалзаж үздэггүй.¹⁰

Хэрэг явдал ийнхүү өндөрлөсний учир шалтгааныг Монголын улс төрийн системийн онцлог, улс төрийн элитүүдийн хүчний харьцаанаас хайх хэрэгтэй болов уу. Монголын ямар ч өндөр тушаалын буюу нэр хүндтэй улс төрч нэгэнт тогтсон хүчний харьцааны улмаас ийм том ашигт малтмалын ордыг эзэмших лицензийн асуудлыг дангаар шийдвэрлэж баараггүй амлалт өгөх бололцоогүй юм. Учир нь асар том ашигт малтмалын ордын хөрөнгө оруулагчийг сонгох асуудлыг олноороо мөн Монголын улс төрийн гол хүчнүүдийн оролцоотой шийдвэрлэх нь зүйн хэрэг. Юуны түрүүнд бид үндсэн хуулийн дагуу шийдвэр гаргах эрх бүхий Монголын парламентыг хэлж байна.

Нөгөөтэйгүүр олон талт бодлогын хүрээнд Улаанбаатар аль нэгэн оронд онцгой эрх олгохыг хүсэхгүй байгаа юм. Монголын удирдагчид Орос, Хятадтай харилцах харилцаагаа тэнцвэржүүлэх зорилгоор бүсийн бус түнш болох АНУ, Канад, Япон, Солонгос, Энэтхэг орнуудаар төлөөлүүлэн “гурав дахь хөрш” хэмээх хөзрийг идэвхтэй тоглож байгаа болно. Оросын болон гадаадын шинжээчид энэ маягийн стратегийг “отложенный нейтралитет”¹¹ буюу “нарийн тэнцвэр” (“delicate balancing”) хэмээн томъёолдог. Оросын удирдлагын зүгээс энэхүү байдлыг ойлгохгүй байх нь эцэстээ социалист хамтын нийгэмлэг нуран унасны дараа манай улсад үлдсэн зарим нэгэн давуу талаа алдахад ч хүргэх аюултай юм. Оросын хувьд үйлдвэрийн объект, хийгээд үйлчилгээний салбар зэрэг Монголын гол гол түүхийн эдийн зах зээлд гарахад ямар нэгэн онцгой эрх байхгүй болсныг ойлгох хэрэгтэй юм. Орос орон бол өрсөлдөөнд оролцож буй /ач холбогдол бүхий ч гэсэн/ гишүүн орнуудын л нэг. Иймээс Оросын удирдлага хийгээд манай орны ажил хэрэгч хүмүүсийн хувьд тэрхүү өрсөлдөөнд оролцож тэмцэл явуулах чадвартай болох нь гол зорилго нь юм. 2000-аад оны үед Москва, Улаанбаатарын хооронд бий болсон улс төрийн харилцааны идэвхжилт Оросын талд Монгол дахь нөлөөний төлөөх тэмцэлд оролцох боломжийг олгосон юм. Тэгэх тусмаа Монголын хувьд чухамдаа Орос оронтой улс төр, цэрэг, эдийн засаг, соёл-шинжлэх ухааны салбарт идэвхтэй харилцаа

тогтоох нь үндэсний аюулгүй байдлын стратегийнх нь хэрэгжилтийн чухал нэг хэсэг юм. Монголын өмнө тулгарч буй олон төрлийн асуудал, бэрхшээл хүндрэл нь Орос орны идэвхтэй оролцоогүйгээр шийдвэрлэгдэхгүй билээ.

Д.А.Медведевийн 2009 оны 8-р сард Монголд хийсэн айлчлалын үеэр хэлсэн Монгол орон “өөрчлөгдөж байна... гэтэл бид үүнийг анзаараагүй тал ч бий энэ нь бидний алдаа ч байж магад юм” гэж хэлсэн нь Монголын талаархи Оросын стратегид нааштай өөрчлөлт бий болох эхлэл болов уу гэсэн найдварыг төрүүлж байна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Москвагийн тунхаг. Москва 2006 оны 12 сарын 8.
/http://www.kremlin.ru /interdocs/2006/12/08/1726 type72067 115119..shtml? type=72067/
2. Мөн тэнд
3. Депутаты-международники отправились в Монголию
(http://www.annews.ru/news/detail.php?ID=157873 Агенство национальных новостей 20.03.2008)
4. “Единая Россия “договорилась о сотрудничестве с ведущей партией Монголии (http://lenta.ru /news/2008/03/25/mongol/
5. Интервью Говорина Б.А. телекомпании Аист-Монголия
http://www.owasia.ru /digest _2008+M5e34937c 04..html #1
6. Монгол Улсын статистикийн эмхтгэл 2009.-Улаанбаатар, 2010.-т.73.
7. Үүнийг 2010 онд Монголд айлчилсан ХКН-ын төв хорооны гадаад бодлогын департаментын тэргүүн Ван Зяжуй-н толгойлсон ХКН-ын төлөөлөгчид Монголын бүх тэргүүлэх намуудын төлөөлөгчидтэй уулзалт зохион байгуулсантай харьцуулж болох юм. http://russian.people.com.cn/31520/7107715.html)
8. ИТАР-ТАСС, 18.06.2009
9. Монголия лишает Россию золота//Коммерсант, №183 (4238), 02.10.2009; Россия теряет Монголию (http://fintimes.km.ru/62973/
10. Монгол Улсын статистикийн эмхтгэл 2009.-Улаанбаатар, 2010. т.73.
11. А.Д.Богатуров, А.С.Дундич, У.Ф.Троицкий. Центральная Азия: “отложенный нейтралитет” и международные отношения в 2000-х годах. Очерки текущей политики. Выпуск 4.-М., 2010

Орос хэлнээс орчуулсан: Н.Ариунгуа (ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор)